Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Улсын төсвөөс санхүүжидэг байсан Дэлүүн сумын Сум дундын эмнэлэг нь бүтцийн өөрчлөлтөөр 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс сумын Төсвийн төвлөрүүлсэн захирагчийн мэдэлд шилжиж, сумын Эрүүл мэндийн төв болж өөрчлөгдөн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд орсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн харъяа орон нутгийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийдэг.

Дэлүүн сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2021 онд шалгалт хийгдээгүй байна.

Тус сумын дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 7,542.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 78.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 62.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 89.8 сая, эцсийн үлдэгдэл 59.9 сая төгрөг болж, 29.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	89.8	59.9	-29.9	100%
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
<b>Дүн</b>	<b>89.8</b>	<b>59.9</b>	<b>-29.9</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 59.9 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

**Аудитын илрүүлэлт:**

Тус сумын төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

**3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт**

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

**3.5.3 Авлага**

Авлага дансны эцсийн үлдэгдэл 336.5 сая төгрөг болж, 2.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	25.1	0.5	-24.6
Бусад авлага	9.8	50.1	40.3
Зээлийн авлага	298.9	285.9	-13
<b>Дүн</b>	<b>333.8</b>	<b>336.5</b>	<b>2.7</b>

Эх сурвалж Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай авлага байхгүй байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 1-ээс 3 жилийн насжилттай авлага ба энэ нь тухай бүр өөрчлөгдөж байна.

Нийт авлагын 285.9 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 10.6 сая төгрөг нь Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн, 0.6 сая төгрөг нь 2 дугаар сургуулийн, 15.0 сая төгрөг нь Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн, 15.0 сая төгрөг нь 2 дугаар цэцэрлэгийн, 5.1 сая төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн, 1.4 сая төгрөг нь Байгаль хамгаалах сангийн, 3.0 сая төгрөг нь Төрийн сангийн авлага байна.

**Аудитын илрүүлэлт:**

Тус сумын ТШЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлагтай холбоотой алдаа зөрчил гараагүй байна.

**3.5.4 Урьдчилгаа**

Урьдчилгаа данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

**3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт**

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс үлдэгдэлгүй байна.

**3.5.6 БАРАА МАТЕРИАЛ**

Бараа материал дансны үлдэгдэл 385.3 сая төгрөг болж, 13.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал		9.4	9.4
Хангамжийн материал	329.9	307.4	-22.5
Мал амьтад	68.5	68.5	0
Нөөцийн бараа	12.1	15	2.9
<b>Дүн</b>	<b>398.4</b>	<b>385.3</b>	<b>-13.1</b>

Эх сурвалж: Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл буурсан нь төсөвт байгууллагууд тайлант онд 582.6 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 32.6 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан ба үйл ажиллагаандаа 598.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 34.6 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, 34.3 сая төгрөгийн бараа материалыг акталсантай холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт:**

Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль бараа материалын дансанд 14.6 сая төгрөгийн бараа материалыг бүртгэж тайлагнасан боловч тооллогыг дутуу хийснээс тооллогын дүнг санхүүгийн тайлангийн дахь үлдэгдэлтэй тулган баталгаажуулах боломжгүй, нярвын бараа материалын бүртгэл хөтлөлт хангалтгүй, хоол хүнсний зарцуулалтын тайлан, нягтлан бодогчийн гаргасан бараа материалын тайлангаас 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй, 0.3 сая төгрөгийн нормын хувцас, тээвэр шатахуунд зарцуулсан 2.9 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн нярвын бараа материалын тайлангийн орлого, зарлагын анхан шатны баримтууд дутуу, бараа материалын үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 1.5 сая төгрөгөөр зөрүүтэй гаргасан.

**3.5.7 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 9,198.0 сая төгрөг болж, 1,297.5 сая төгрөгөөр өссөн байна. Хүснэгт №4. /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	7,775.50	9,056.10	1,280.60
Биет бус хөрөнгө	125	141.9	16.90
<b>Дүн</b>	<b>7,900.50</b>	<b>9,198.00</b>	<b>1,297.50</b>

Эх сурвалж: Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 41.6 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 544.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсөвт байгууллагууд тайлант онд 707.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж 104.3 сая төгрөгийн гарз бүртгэж, үндсэн хөрөнгөнд 346.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

Ерөнхий боловсролын 2 дугаар сургуул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 133, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 48 дугаар тогтоолоор 14.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан боловч Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж, дүгнэлт гаргуулаагүй, устгал хийж баримтжуулаагүй байна.

Санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийн дансанд 404.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хөрөнгийн нэг бүрийн үнэ, нийт дүнгээр гаргаагүй, дутуу тоолсоноос тооллогын бүртгэлийн дүнг санхүүгийн тайлангийн дахь үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулах боломжгүй байна. Хандиваар хүлээн авсан 15.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн баримтын бүрдэл дутуу, 0.6 сая төгрөгийн принтерийг орлого аваагүй байна.

Эрүүл мэндийн төв жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийхдээ 248.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу тоолсон, тооллогын бүртгэлийн дүнгүүд нь зөрүүтэй,

тооллогын дүнг санхүүгийн тайлан дахь хөрөнгийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулах боломжгүй, өмнөх оны аудитаар үндсэн хөрөнгийн тооллогыг дутуу хийсэн зөрчлийг давтан гаргаж, өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 104.4 сая төгрөг болж, 16.1 сая төгрөгөөр буурсан байна.  
Хүснэгт №5. /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	12.1		-12.1	
Бараа үйлчилгээний зардлын өглөг	6.6	26.6	20	25.5%
Байгууллагад төлөх өглөг	101.7	77.8	-23.9	74.5%
Хувь хүмүүст төлөх өглөг	0.1		-0.1	
<b>Нийт дүн</b>	<b>120.5</b>	<b>104.4</b>	<b>-16.1</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн 25.5 хувийг буюу 26.6 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардлын, 74.5 хувийг буюу 77.8 сая төгрөгийг байгууллагад төлөх өглөг тус тус эзэлж байна.

Төсөвт байгууллагуудаас Засаг даргын тамгын газар 4.1 сая, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 52.3 сая, Эрүүл мэндийн төв 23.8 сая, Орон нутгийн хөгжлийн сан 24.1 сая төгрөгийн өглөгтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Эрүүл мэндийн төв санхүүгийн тайлангаар 23.8 сая төгрөгийн өглөгтэй боловч эм ханган нийлүүлэх 4 байгууллагын 6.8 сая төгрөгийн өглөгөөс бусад тооцооны үлдэгдэлийг баталгаажуулаагүй байна

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Хүснэгт № 6 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

/САЯ ТӨГРӨГ

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,474.70	2,694.10	219.40	27.2%
Хуримтлагдсан үр дүн	2,647.40	3,550.60	903.20	35.9%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,491.80	3,645.80	154.00	36.9%
<b>Дүн</b>	<b>8,613.90</b>	<b>9,890.50</b>	<b>1,276.60</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,276.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой 1,289.8 сая төгрөгийн нэмэгдүүлэх бичилт гарсан, дахин үнэлгээний нөөцийг 106.8 сая төгрөгөөр бууруулсан, тайлант оны үр дүн 93.6 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 3,550.6 сая төгрөг болж 903.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 93.6 сая төгрөг гарсан болон 809.6 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой өмнөх оны үр дүнг нэмэгдүүлнээс шалтгаалжээ.

### 3.5.10 Орлогын данс

Дэлүүн сум нь 2021 онд гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 251.6 сая төгрөгийн орлого оруулж, тусламж санхүүжилтийн орлогоор тусгай зориулалтын шилжүүлгээс 5,012.1 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 722.7 сая төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сангаас 293.9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 46.3 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 95.7 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээр 128.9 сая төгрөгийн орлого, үнэ төлбөргүйгээр 544.6 сая төгрөгийн хөрөнгө, 32.8 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч нийтдээ 7,046.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

### 3.5.11 Зардлын данс

Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар урсгал зардал 6,557.9 сая, үйл ажиллагааны бус зардал 394.4 сая төгрөг байна.

Урсгал зардлын 4,400.8 сая төгрөг буюу 67.1 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшлын, 600.4 сая төгрөг буюу 9.2 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн, 347.5 сая төгрөг буюу 5.2 хувийг байр ашиглахтай холбоотой тогтмол зардал, 165.5 сая төгрөг буюу 2.5 хувийг хангамж, бараа материалын зардал, 379.8 сая төгрөг буюу 5.9 хувийг нормативт зардал, 418.3 сая төгрөг буюу 6.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 204.0 сая төгрөг буюу 3.1 хувийг урсгал шилжүүлэг, 0.7 хувийг бусад зардал эзэлж байна.

#### Аудитын илрүүлэлт:

*Төсөвт байгууллагуудаас Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үзэхэд 1.1 дэх заалтад хамаарах байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь буюу ИТХурал 1.6 сая, ЗДТГ 9.3 сая, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 3.2 сая, 2 дугаар сургууль 0.8 сая, 3 дугаар сургууль 0.9 сая, Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг 1.2 сая, 2 дугаар цэцэрлэг 3.9 сая төгрөгийг хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.*

*Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль гэрэл цахилгаан, түлш халаалт, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан, холбоо, интернэтийн төлбөр, хог хаягдал зайлуулах, эм, хоол, хүнс, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлуудаас нийтдээ 262.9 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй бүртгэж тайлагнасан.*

*Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль шуудан холбооны зардлаас 0.7 сая төгрөгийг бүрдэл дутуу баримтаар шилжүүлсэн.*

*Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг эрхлэгчид БСУГ-ын даргын тушаалын хавсралтад заасан хувь хэмжээнээс 0.4 сая төгрөгийн, нягтлан бодогчид цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалд зааснаас 0.2 сая төгрөгийн урамшууллыг илүү олгосон. Тээвэр, шатахуун, шуудан холбоо интернетийн төлбөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, нормын хувцас, зөөлөн эдлэл, бага үнэтэй түргэн элэгдэх зардлын төсвөөс худалдан авсан нийт 3.6 сая төгрөгийн зардлуудыг холбогдох тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, 1.5 сая төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг зардлаар хүлээн бүртгэсэн.*

*Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг эрхлэгчид 0.7 сая төгрөгийн урамшуулал, нэмэгдлийг, нягтлан бодогчид 0.1 сая төгрөгийн цалинг, түр ажилласан нягтлан бодогчид төрийн алба хаасны нэмэгдэлд 0.2 сая төгрөгийг холбогдох эрхийн актгүй олгосон. Туслах багшид 0.4 сая төгрөгийн цалингийн зөрүүг баримтгүй илүү олгосон.*

Эрүүл мэндийн төв нягтлан бодох бүртгэлийн заавал хөтлөх журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс бүртгэлийг хөтлөөгүй, санхүүгийн программыг бүрэн ашиглаагүй, санхүүгийн тайлангийн тодруулга, төсвийн гүйцэтгэлийн танилцуулгыг зааврын дагуу бэлтгэж ирүүлээгүй, нийт 176.6 сая төгрөгийн зарлагын гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, 2021 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанаас 23 хоног хоцроож 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр ирүүлсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Дэлүүн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 6,480.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 6,186.9 сая төгрөгийг урсгал зардалд, 293.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталсан байна.

Нийт зардлын 5,013.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,022.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 293.9 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 56.6 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 94.3 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### Төсвийн гүйцэтгэл

Дэлүүн сум нь 2021 онд гүйцэтгэлээр нийтдээ 6,433.7 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлснээс тусгай зориулалтын шилжүүлгээс 4,975.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 1,022.0 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 46.3 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 293.3 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 95.7 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Нийт санхүүжилтээс 36,6 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн ба ЭМД-ын сангаас 10.4 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, үндсэн үйл ажиллагааны орлого 4.7 сая төгрөгөөр давж биелсэн үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,417.3 сая төгрөг буюу 99 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилттэй холбоотой байна.

#### Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар:

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	100.9	100.5	-0.4
2	Сумын ЗДТГ	498.79	498.77	-0.01
3	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль	3,068.7	3,067.3	-1.4
4	Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	244.0	243.0	-1.0
5	Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	236.6	236.1	-0.5
6	1 дүгээр цэцэрлэг	566.6	545.6	-21.1
7	2 дугаар цэцэрлэг	418.4	404.7	-13.7
8	Соёлын төв	70.2	70.2	0.0
9	Эрүүл мэндийн төв	888.2	877.8	-10.4
10	ОНХСан	293.9	293.9	0.0
11	СХС	88.5	73.5	-14.9
12	БОХСан	5.8	5.8	0
	<b>Нийт дүн</b>	<b>6,480.8</b>	<b>6,417.3</b>	<b>-63.4</b>

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Аймгийн ИТХ-ын 2020 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 16 дугаар тогтоолоор Дэлүүн сумын 2021 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 219.3 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 2021 оны 41 дүгээр тодотголоор 219.3 сая төгрөгөөр хэвээр нь баталсан байна.

Дэлүүн сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн төсөвт тодотгол хийх тухай 17 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 219.3 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 251.6 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 32.3 сая төгрөгөөр буюу 14.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт №7 Дэлүүн сумын 2021 оны орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл*

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				дүнгээр	хувиар
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>219.3</b>	<b>251.6</b>	<b>32.3</b>	<b>100%</b>
	<b>УРСГАЛ ОРЛОГО</b>	<b>219.3</b>	<b>251.6</b>	<b>32.3</b>	<b>100%</b>
<b>1</b>	<b>I, ТАТВАРЫН ОРЛОГО</b>	216.8	244.3	<b>27.5</b>	97.10%
<b>2</b>	<b>II.Татварын бус орлого</b>	2.5	7.3	<b>4.8</b>	2.90%

*Эх сурвалж: Дэлүүн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн орлогын мэдээ*

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 32.3 сая төгрөгөөр давж биелэхэд ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого, үйл ажиллагааны орлого, хөрөнгө борлуулсаны орлого болон торгуулийн орлогууд давж биелсэн нь нөлөөлсөн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд хөрөнгийн орлогын татвар 0.6 сая, улсын тэмдэгтийн хураамж 1.3 сая, газрын төлбөр 2.0 сая төгрөгөөр тасарч, үйл ажиллагааны орлого 7.8 сая, хөрөнгө борлуулсаны орлого 6.3 сая, бууны татвар 1.1 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.9 сая, ан, амьтны нөөц ашигласны төлбөр төлбөр 15.3 сая, татварын бус орлого 4.8 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна.

Татварын бус орлогоос торгуулийн орлого 4.8 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 80.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 251.6 сая төгрөгийн татварын орлого, 722.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авч төсөвт байгууллагуудаас 2.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орон нутгийн төсөвт байгууллагуудад 1,022.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 35.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 112.9 сая төгрөгийн, хандив тусламжаар 4.8 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 11.3 сая төгрөгийн нийт 128.9 сая нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс цалин хөлстэй холбоотой зардалд 26.3 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 0.6 сая, хангамж, бараа материалын зардалд 6.9 сая, нормативт зардалд 3.3 сая, томилолт, зочны зардалд 2.4 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 23.2 сая,

урсгал шилжүүлэгт 66.3 сая төгрөгийг зарцуулж, төсөвт 0.008 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого ороогүй байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тайлан дахь мэдээллээр 2021 онд нийт 6,087.5 сая төгрөгийн 79 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 67 мэдээллийг хоцроож, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус Дэлүүн сумын ТТЗ-ийн багцад хамаарах 12 байгууллага, нэгжийг хамруулан, мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны мэдээлсэн байдлыг шалгахад тайлант онд төсвийн гүйцэтгэлийн 1, 2, 3, 4 дүгээр улирлын мэдээг оруулаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 106.7 сая төгрөгийн худалдан авалтын мэдээллийг байршуулаагүй, 288.9 сая төгрөгийн авлага үүсгэсэн шийдвэрийг байршуулаагүй байна.

Сумын төсөвт байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудитын дүнгээр Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудад албан шаардлага, ЗДТГ, Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль, Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгт зөвлөмж өгөгдсөн байна.

#### Аудитын илрүүлэлт:

*Сумын ЗДТГ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6.2 сая төгрөгийн 1 худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягыг оруулаагүй, 4.1 сая төгрөгийн өр үүсгэсэн 2 шийдвэрийг оруулаагүй байна.*

*Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль Шилэн дансны таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 257.3 сая төгрөгийн 20 гүйлгээний худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 18.6 сая төгрөгийн 2 гүйлгээг хугацаа хоцроож оруулсан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 267.3 сая төгрөгийн 2 гүйлгээг хугацаа хоцроож оруулсан, 52.5 сая төгрөгийн өр үүсгэсэн тухай 2 шийдвэр, 10.6 сая төгрөгийн авлага үүсгэсэн 1 шийдвэрийг оруулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна*

Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль шилэн дансанд тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Эрүүл мэндийн төв Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 977.8 сая төгрөгийн 145 мэдээллийг ил тод байршуулахаас 58 мэдээллийг хугацаандаа байршуулж, 27 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс 31.9 сая төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй, 87 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, өмнөх оны аудитаар шилэн дансны 63 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг давтан гаргаж, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 12 гүйлгээнээс 35.9 сая төгрөгийн дүн бүхий 1 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын 34.6 сая төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй, авлага үүсгэсэн талаарх 15.0 сая төгрөгийн 1 мэдээллийг оруулаагүй байна

Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг шилэн дансанд санхүүжилтийн 28.2 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 64.8 сая төгрөгийн 4 мэдээллийг огт мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш нийт худалдан авалтын зарлагын 6.4 сая төгрөгийн 1 гүйлгээ, 15.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн тухай шийдвэрийг мэдээлээгүй зэргээр нийт 114.4 сая төгрөгийн зөрчил гаргасан.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Дэлүүн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчид Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, шилэн дансанд заавал байршуулах мэдээллийг бүрэн байршуулах талаар 1 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Хүснэгт 8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	6.0		1.5	1	4.5	25%
Албан шаардлага	2	20.1	2	20.1	0	0	100%
Зөвлөмж	1	0			1	0	0%
<b>Нийт</b>	<b>4</b>	<b>26.1</b>	<b>2</b>	<b>21.6</b>	<b>2</b>	<b>4.5</b>	<b>41.6%</b>

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 9 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 13 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 7 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 2 сангийн санхүүгийн тайланг нэгтгэсэн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын 1, 3 дугаар сургуулиуд, Хүүхдийн 1, 2 дугаар цэцэрлэгүүдийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулиудын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Сумын ИТХ, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудын тайланг түүвэрт хамруулж, Байгаль хамгаалах сан, Төрийн сангуудын тайланг нэгтгэсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 395.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 395.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, санхүүгийн албаны даргын албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбоотой зөрчилд зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой залруулга гараагүй байна.

**Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчид шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 395.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3,024.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс Хүүхдийн 1, 2 дугаар цэцэрлэг, Сум хөгжүүлэх сангуудын санхүүгийн тайланд 517.4 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

Хүүхдийн 1, 2 дугаар цэцэрлэгүүдэд 1.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоогдож, ЗДТГ, Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургууль, Хүүхдийн 1, 2 дугаар цэцэрлэгүүдэд 384.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, сумын бүх төсөвт байгууллага болон ОНХС, СХС-уудад 1,983.4 сая төгрөгийн зөрчлийн дүнгээр зөрчил арилгах албан шаардлага өгөгдсөн байна. Эрүүл мэндийн төвийн эрхлэгчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн байна.

Хүснэгт 8: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс										
				Залруулсан алдаа		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж		Албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			Тоо
А	В	5	6	7	8	11	12	13	14	15	16	17	18	
1	ИТХурал	1	1.6					1	1.6					
2	ЗДТГазар	2	19.6					1	9.3	1	10.3			
3	ЕБ-ын 1 дүгээр сургууль	3	872.3					2	609.4	1	262.9			
4	ЕБ-ын 2 дугаар сургууль	4	171.6					2	157.1	2	14.5			
5	ЕБ-ын 3 дугаар сургууль	1	0.9					1	0.9					
6	Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг	5	94.1	1	0.2	1	0.6	1	1.2	2	92.1			
7	Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг	6	471.8	2	347.3	1	1.4	2	118.3	1	4.9			
8	Эрүүл мэндийн төв	3	524.3					2	524.3				1	
9	Орон нутгийн хөгжлийн сан	1	561.4					1	561.4					
10	Сум хөгжүүлэх сан	3	306.8	2	169.8			1	137.0					
	<b>Дүн</b>	<b>29</b>	<b>3,024.4</b>	<b>5</b>	<b>517.4</b>	<b>2</b>	<b>1.9</b>	<b>13</b>	<b>1983.4</b>	<b>7</b>	<b>384.7</b>	<b>1</b>	<b>0</b>	

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1 Албан тушаалын гүйцэтгэх чиг үүргийн талаар

#### 1.1. Илрүүлэлт:

Сумын Орон нутгийн хөгжлийн сан болон Сум хөгжүүлэх сангийн 2 дугаар гарын үсгийг Засаг даргын тамгын газрын Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн зурж, тайлан баланс гаргасан байна.

Энэ нь Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Санхүүгийн албаны даргын ажлын байрны тодорхойлолтын албан тушаалын 2 дугаар зорилтын 12, 3 дугаар зорилтын 1-д заасныг зөрчсөн байна.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан сумын Санхүүгийн албаны ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангуудын 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны даргаар зуруулж, тайлан, баланс гаргуулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дэлүүн сумын ТТЗ	2	395.1					1	395.6	1	